

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2018 оны 5-р сарын дугаар

Тэргүүн Мэдээ

“Маружо”ХК-д үйлдвэрлэсэн М-01 бэхэлгээтэй төмөр бетон дэрийг Улаанбаатар төмөр замын гол шугамд суурилууллаа.



5 дугаар сарын 11-ний өдөр ЖАЙКА-ийн “Японы жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн гадаадад бизнесээ өргөжүүлэхийг дэмжих хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Төмөр замын тахир хэсэгт бетон дэрний бэхэлгээг нэвтрүүлэх, турших төсөл”-өөр “Маружо”ХК-д үйлдвэрлэсэн М-01 бэхэлгээтэй төмөр бетон дэрийг Улаанбаатар төмөр замын гол шугамын 1 км орчим тахир хэсэгт суурилууллаа. Энэхүү төхөөрөмжийг суурилуулснаар төмөр замын царигийн өргөний өөрчлөлт үүсэхгүй, эдэлгээ урт, засвар арчлалтын зардлыг бууруулахаас гадна төмөр замын аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулна гэж үзэж байгаа юм. Цаашид УБТЗ-ын ашиглалтын явцад төхөөрөмжийн үр ашигтай байдлыг баталгаажуулах юм.

Улс төр, эдийн засгийн чиг хандлага

“Монголын эдийн засгийн чуулган 2018”

5 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Засгийн газрын ордонд Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл доор “Монголын эдийн засгийн чуулган 2018” зохион байгуулагдав. Энэхүү чуулганыг Засгийн газар, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчидтай Монгол улсын эдийн засгийн байдал, хөрөнгө оруулалтын орчны талаар өргөн хүрээтэй санал солилцох зорилгоор жил бүр зохион байгуулдаг юм. 2018 оны чуулган “Хүчээ нэгтгэе” гэсэн уриан дор явагдаж, Монгол Улсын хөгжлийн загвар, улсын хөрөнгө оруулалтын бодлого, төр хувийн хэвшлийн түншлэлийн ач холбогдол, уул уурхайн төслүүдийн хэрэгжилтийн байдлын талаар илтгэл тавигдахын зэргээсээ ХАА, аялал жуулчлал зэрэг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн ирээдүйтэй гэж үзэж буй салбаруудад тулгарч буй асуудал болон боломжийн талаар санал солилцон уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэхийн ач холбогдлыг дахин хүлээн зөвшөөрсөн чуулган болов.


Төслийн хэрэгжилт

Эмнэлзүйн сургагч багш бэлтгэх улсын хэмжээний анхны сургалт болов.



5 сарын 14-16-ны өдрүүдэд ТХА-ны “Монгол Улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд эмнэл зүйн сургагч багш бэлтгэх улсын хэмжээний анхны сургалт зохион байгуулагдлаа. Энэхүү төслийн хүрээнд Японы анагаах ухааны боловсролын салбарт арвин туршлагатай мэргэжилтэн багш нараар удирдуулан өнөөг хүртэл 250 сургагч багш бэлтгэгдсэн. Энэ удаа сургагч багш нарыг улсын хэмжээнд бэлтгэх эхний алхам болж байгаа ба өнцөг булан бүрээс оролцож буй 64 эмчийг “Эмнэл зүйн сургагч багш”-аар бэлтгэхэд, үндэсний 12 чиглүүлэгч багш болон холбогдох талуудын дэмжлэгтэйгээр сургалтыг зохион байгууллаа.

“Улаанбаатар хотын ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг сайжруулах” хамтын ажиллагааны төслийн хүрээнд Саппоро хотын УСУГ-ын мэргэжилтэн Монгол улсад ирэв.



Өвсний үндэс ТХА-ны “Улаанбаатар хотын ус дамжуулах, түгээх үйл ажиллагааг сайжруулах” хамтын ажиллагааны төслийн хүрээнд Саппоро хотын УСУГ (Япон талын гүйцэтгэгч байгууллага) Улаанбаатар хотын элэгдэл явагдаж буй ус түгээх, дамжуулах байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцдаг УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор шугам сүлжээний технологийн суурь мэдлэг олгох, сайжруулах төлөвлөгөө боловсруулахад чиглэсэн чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулав. 5 сард Саппоро хотын УСУГ-ын мэргэжилтэн туршилтын төсөлд хамрагдсан нутаг дэвсгэрийн сайжруулах төлөвлөгөө боловсруулах чиглэлээр практик сургалт зохион байгуулсан нь 11 сард өндөрлөх уг төслийн томоохон үр дүнг харуулсан арга хэмжээ боллоо.

“Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх нь” төслийн хамтарсан зохицуулах хорооны хурал болов.



Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн 2018 оны анхдугаар хамтарсан зохицуулах хорооны хурал 5-р сарын 10-ны өдөр зохион байгуулагдав. “Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх нь” техникийн хамтын ажиллагааны энэхүү төслийн хүрээнд тус төвийн менежментийг сайжруулах, бизнесийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг ажлууд хийгдэж байна. Энэ удаагийн хурлаар төвийн үйл ажиллагааны орлого өмнөх жилүүдээс эрс нэмэгдэж, 2017 онд төлөвлөсөн ажлууд амжилттай хэрэгжсэнийг хэлэлцэхийн сацуу 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа.

Япон улсад “Японы тэтгэврийн тогтолцоо болон өдөр тутмын практик үйл ажиллагаа” сэдэвт сургалт зохион байгуулав.



5-р сарын 13-25-ны өдрүүдэд, ТХА “Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд Япон улсад “Японы тэтгэврийн тогтолцоо болон өдөр тутмын практик үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Монголоос НДЕГ зэрэг байгууллагын 15 хүн оролцов. Энэхүү сургалтаар нийгмийн даатгалын газрын үйл ажиллагааны ажил үүргийн хуваарилалт болон үйлчлүүлэгчтэй харилцах, үйлчлүүлэгчийг дээдлэсэн үйлчилгээний аргазүйг танилцуулж, Япон улсын өдөр тутмын практик ажлын талаарх ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэв. Цаашид сургалтаар олж авсан ноухауг Монголын тэтгэврийн салбарын үйл ажиллагааг сайжруулахад бүтээлчээр ашиглана гэдэгт найдаж байна.

Бусад төслийн үйл ажиллагаа

- 5 сарын 16: Урт хугацааны мэргэжилтэн Хигашида (Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл) томилогдон ирэв.
- 5 сарын 30: Урт хугацааны мэргэжилтэн Исобэ (Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл) буцав.

Сайн дурын үйл ажиллагаа

Эрдэнэт хотод гамшгаас хамгаалах семинар зохион байгуулагдлаа.



4 сарын 23-ны өдөр Эрдэнэт хотод сайн дурын гишүүн Юкава Чиаки (2016 оны 2-р ээлж/Хүүхэд залуучуудыг хөгжүүлэх үйл ажиллагаа), Оцуки Мика (2016 оны 1-р ээлж/Хөдөлмөр засалч) нар МУЗН-ийн Эрдэнэт хотын салбартай хамтран гамшгаас хамгаалах семинарыг зохион байгууллаа. Монгол оронд цас зуд гэх мэт хэзээ ч нүүрлэж мэдэх гамшгийн эрсдэл өндөр байдаг. Тус семинарт аврах анги, төрийн захиргааны байгууллагын ажилтнууд зэрэг нийт 140 гаруй хүн оролцсон бөгөөд гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдлийг бууруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Сайн дурын бусад үйл

ажиллагааны мэдээ

Дэлхий даяарх ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагааны тэмдэглэл: Оно Юки (2016 он 2 сар/нийгмийн ажилтан)

→[линк](#), Нацуми Адачи(2016 он 3 сар/теннис)→[линк](#)

ЖАЙКА-ийн Сургалт төгсөгчдийн холбоо



2017 оны “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-дийг танилцуулж байна. “Боловсролын чанарыг дээшлүүлэх нь” сургалтанд оролцогч.



Булган аймгийн Хишиг-Өндөр сумын ЕБС-ийн Сургалтын менежер Ч.Алимаа нь 2012 оны 6 дугаар сард Токио хотноо зохион байгуулагдсан “Боловсролын чанарыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтанд оролцсоноос хойш Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн багш нарт Японы хичээлийн судалгаа, самбар төлөвлөлтийн талаар танилцуулах үзэсгэлэн, сургалтууд нэлээд зохион байгуулж ирсний үр дүнд багш нарын самбар төлөвлөлт сайжирч, хичээлийн чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулж чадсан байна. Түүний энэхүү хүчин чармайлтыг өндрөөр үнэлж, ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбооны 2017 оны “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-ээр шалгарууллаа.



Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.

(ЖАЙКА) Монгол дахь Төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp